ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Өндөр сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ОРА-2022/08/НА-СТА-ТШ3**

Цахим хуудас: www.audit.mn

Эрдэнэт хот

2022 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ
Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn

Ахлах аудитор: В.Жавзмаа
Утас: 70357955 Цахим хаяг: javzmaav@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт ....2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл....4
3. Аудитын тайлан ....13
3.1 Ерөнхий зүйл ....13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт....13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ....13
3.4 Материаллаг байдал ....14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ....14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ....14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг....15
3.8 Аудитын гол асуудал ....16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт....16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал....17
4. Аудитын илрүүлэлт....17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ....18

### Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.02.25 № 76

танай ________ -ны № ________ -т

БАЯН-ӨНДӨР СУМЫН ЗДТГ-ЫН
ДАРГА Ш.ӨЛЗИЙБАЯР ТАНАА

**Аудитын санал дүгнэлт**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Өндөр сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Өндөр сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

D:\my doc \alban bichig\ 2022-A4.doc

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРМАНДАХ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **101,171,649.88** | **156,088,831.88** |
| **33** | **АВЛАГА** | 4,500,000.00 | 38,164,192.00 |
| **335** | **Бусад авлага** | 4,500,000.00 | 38,164,192.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 4,500,000.00 | 38,164,192.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 96,671,649.88 | 117,924,639.88 |
| **351** | **Түүхий эд материал** | 34,485,990.03 | 35,831,990.03 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 34,485,990.03 | 35,831,990.03 |
| **354** | **Хангамжийн материал** | 62,185,659.85 | 82,092,649.85 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 191,799.85 | 360,449.85 |
| 35420 | Аж ахуйн материал | 11,993,860.00 | 33,932,460.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 50,000,000.00 | 47,799,740.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **7,801,805,625.50** | **9,484,492,497.65** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 7,801,805,625.50 | 9,484,492,497.65 |
| **392** | **Биет хөрөнгө** | 7,406,350,625.61 | 9,090,612,497.80 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 6,663,625,384.08 | 8,547,371,451.08 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (552,203,353.87) | (891,083,128.49) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 162,749,800.00 | 161,744,800.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (58,098,233.25) | (81,129,241.63) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 1,088,148,338.65 | 1,158,491,404.66 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (487,603,120.96) | (571,626,799.69) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 405,443,275.18 | 450,373,775.18 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (154,199,824.24) | (201,518,093.81) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 574,233,657.00 | 835,375,071.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | (235,745,296.98) | (317,386,740.50) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 395,454,999.89 | 393,879,999.85 |
| 39301 | Програм хангамж | 9,262,000.00 | 9,262,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (6,762,000.11) | (8,762,000.15) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 392,955,000.00 | 393,380,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **7,902,977,275.38** | **9,640,581,329.53** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **4,500,000.00** | **38,164,192.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 4,500,000.00 | 38,164,192.00 |
| **413** | **Өглөг** | 4,500,000.00 | 38,164,192.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 4,500,000.00 | 38,164,192.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **7,898,477,275.38** | **9,602,417,137.53** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 7,898,477,275.38 | 9,602,417,137.53 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,728,670,366.14 | 1,729,095,366.14 |
| 51101 | Өмч: - төрийн | 1,728,670,366.14 | 1,729,095,366.14 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 5,704,711,181.81 | 7,408,226,043.96 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 5,704,711,181.81 | 5,704,711,181.81 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 1,703,514,862.15 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 465,095,727.43 | 465,095,727.43 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **7,902,977,275.38** | **9,640,581,329.53** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **6,202,769,833.74** | **5,875,018,888.01** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **3,504,070,873.74** | **2,919,212,483.01** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 3,504,070,873.74 | 2,919,212,483.01 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 3,504,070,873.74 | 2,919,212,483.01 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 3,504,070,873.74 | 2,919,212,483.01 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,698,698,960.00** | **2,955,806,405.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 347,963,460.00 | 256,725,005.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 231,039,700.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 330,221,460.00 | 18,590,304.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 17,742,000.00 | 7,095,001.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 2,350,735,500.00 | 2,699,081,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 2,350,735,500.00 | 2,699,081,400.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **3,324,083,146.66** | **3,728,015,848.74** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **3,322,023,146.66** | **3,691,180,040.74** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 3,250,517,798.30 | 3,450,868,015.95 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,929,063,308.00 | 1,840,518,360.92 |
| 210101 | Үндсэн цалин | 1,084,300,046.00 | 1,481,916,253.12 |
| 210102 | Нэмэгдэл | 666,161,213.00 | 316,571,096.80 |
| 210104 | Урамшуулал | 110,880,000.00 | - |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 67,722,049.00 | 42,031,011.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 245,275,777.58 | 243,215,246.21 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 198,386,518.18 | 170,632,253.66 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 12,164,215.42 | 18,044,960.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 9,361,772.24 | 14,986,440.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,305,756.56 | 3,670,200.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 23,057,515.18 | 35,881,392.55 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 83,702,199.81 | 175,724,073.27 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 34,224,999.81 | 116,012,080.69 |
| 210302 | Түлш, халаалт | 31,285,000.00 | 37,390,994.12 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 18,192,200.00 | 22,320,998.46 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 168,719,833.25 | 182,299,217.81 |
| 210401 | Бичиг хэрэг | 60,799,100.00 | 81,857,328.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 32,707,000.00 | 37,876,716.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 53,219,962.25 | 47,591,423.81 |
| 210404 | Ном, хэвлэл | 3,499,990.00 | 3,087,500.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 8,127,781.00 | 2,850,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 10,366,000.00 | 9,036,250.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 17,727,500.00 | 12,262,100.00 |
| 210502 | Хоол, хүнс | 900,000.00 | 1,662,100.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 16,827,500.00 | 10,600,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 73,668,000.00 | 85,003,825.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,187,340.00 | - |
| 210602 | Тавилга | 397,760.00 | 1,211,300.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 2,839,960.00 | 7,677,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 68,242,940.00 | 76,115,025.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,766,040.00 | 1,541,613.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,766,040.00 | 1,541,613.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 164,591,274.00 | 169,783,340.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 153,128,721.00 | 156,010,610.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 750,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 4,560,000.00 | 4,000,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 352,553.00 | 424,730.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 200,000.00 | 250,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 5,000,000.00 | 8,000,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 600,000.00 | 1,098,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 566,003,865.66 | 740,520,239.74 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 68,780,575.00 | 85,128,850.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,834,000.00 | 3,450,750.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 495,389,290.66 | 651,940,639.74 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 71,505,348.36 | 240,312,024.79 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 55,608,900.00 | 101,396,403.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 29,417,000.00 | 43,825,300.00 |
| 213206 | Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт | 600,000.00 | 384,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 7,748,000.00 | 29,807,200.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 17,843,900.00 | 27,379,903.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 15,896,448.36 | 138,915,621.79 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 15,896,448.36 | 138,915,621.79 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **2,060,000.00** | **36,835,808.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 2,060,000.00 | 36,835,808.00 |
| 220001 | Барилга байгууламж | 2,060,000.00 | - |
| 222001 | Тоног төхөөрөмж | - | 36,835,808.00 |
| **2260** | **Гадаад эх үүсвэрээр** | - | - |
| 226001 | Гадаад эх үүсвэрээр | | |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **2,878,686,687.08** | **2,147,003,039.27** |
| **145** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | - | - |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 383,047,350.74 | 443,488,177.12 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 69,855,012.82 | 433,488,177.12 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 313,192,337.92 | 10,000,000.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (383,047,350.74) | (443,488,177.12) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **2,495,639,336.34** | **1,703,514,862.15** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 1,728,670,366.14 | 465,095,727.43 | 5,704,711,181.81 | 7,898,477,275.38 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,728,670,366.14** | **465,095,727.43** | **5,704,711,181.81** | 7,898,477,275.38 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | - | - | - |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| Тайлант үеийн үр дүн | - | - | | - |
| **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,728,670,366.14** | **465,095,727.43** | **5,704,711,181.81** | 7,898,477,275.38 |
| **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **1,728,670,366.14** | **465,095,727.43** | **5,704,711,181.81** | 7,898,477,275.38 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,728,670,366.14** | **465,095,727.43** | **5,704,711,181.81** | 7,898,477,275.38 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 425,000.00 | - | - | 425,000.00 |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 1,703,514,862.15 | 1,703,514,862.15 |
| **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,729,095,366.14** | **465,095,727.43** | **7,408,226,043.96** | 9,602,417,137.53 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **2,725,002,011.00** | **2,960,306,405.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,725,002,011.00** | **2,960,306,405.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 347,963,460.00 | 261,225,005.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 235,539,700.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 330,221,460.00 | 18,590,304.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 17,742,000.00 | 7,095,001.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 2,350,735,500.00 | 2,699,081,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 2,350,735,500.00 | 2,699,081,400.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **2,729,212,211.00** | **2,912,949,897.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,729,212,211.00** | **2,912,949,897.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,627,247,711.64** | **2,672,637,872.21** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,929,063,308.00 | 1,847,120,375.13 |
| 210101 | Үндсэн цалин | 1,054,654,436.00 | 1,488,253,652.33 |
| 210102 | Нэмэгдэл | 695,806,823.00 | 316,571,096.80 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 67,722,049.00 | 42,295,626.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 245,275,777.58 | 236,613,232.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 198,386,518.18 | 163,210,132.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 12,164,215.42 | 18,350,800.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 9,361,772.24 | 14,680,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,305,756.56 | 3,670,200.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 23,057,515.18 | 36,701,500.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 83,702,199.81 | 175,724,073.27 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 34,224,999.81 | 116,012,080.69 |
| 210302 | Түлш, халаалт | 31,285,000.00 | 37,390,994.12 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 18,192,200.00 | 22,320,998.46 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 167,462,533.25 | 178,449,603.81 |
| 210401 | Бичиг хэрэг | 60,511,300.00 | 81,707,178.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 31,765,000.00 | 32,243,052.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 53,219,962.25 | 47,591,423.81 |
| 210404 | Ном, хэвлэл | 3,499,990.00 | 3,300,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 8,127,781.00 | 2,850,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 10,338,500.00 | 10,757,950.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 7,900,000.00 | 16,662,100.00 |
| 210502 | Хоол, хүнс | 900,000.00 | 1,662,100.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 7,000,000.00 | 15,000,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 72,804,500.00 | 85,811,125.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210602 | Тавилга | 397,760.00 | 1,211,300.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 1,599,960.00 | 6,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 68,619,440.00 | 78,599,825.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,766,040.00 | 1,541,613.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,766,040.00 | 1,541,613.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 94,773,353.00 | 117,215,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 83,310,800.00 | 103,442,270.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 4,560,000.00 | 4,000,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 352,553.00 | 424,730.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 200,000.00 | 250,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 5,000,000.00 | 8,000,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 600,000.00 | 1,098,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 24,500,000.00 | 13,500,750.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 22,500,000.00 | 9,940,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,000,000.00 | 3,560,750.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **101,964,499.36** | **240,312,024.79** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 81,568,051.00 | 101,396,403.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 29,417,000.00 | 43,825,300.00 |
| 213206 | Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт | 600,000.00 | 384,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 7,748,000.00 | 29,807,200.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 17,500,000.00 | 27,379,903.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 20,396,448.36 | 138,915,621.79 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 20,396,448.36 | 138,915,621.79 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **(4,210,200.00)** | **47,356,508.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **2,789,800.00** | **47,356,508.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **2,789,800.00** | **47,356,508.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 2,789,800.00 | 47,356,508.00 |
| 220001 | Барилга байгууламж | - | 36,835,808.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 2,789,800.00 | 10,520,700.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(2,789,800.00)** | **(47,356,508.00)** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **-** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 7,000,000.00 | - |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 2,699,081,110.00 | 2,592,255,895.21 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 2,699,081,110.00 | 2,592,255,895.21 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,644,720,560.00 | 2,537,911,492.21 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,805,078,490.00 | 1,804,824,749.13 |
| 210101 | Үндсэн цалин | 838,083,810.00 | 1,488,253,652.33 |
| 210102 | Нэмэгдэл | 257,147,880.00 | 316,571,096.80 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 79,846,800.00 | - |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 630,000,000.00 | - |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 231,219,740.00 | 231,219,900.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 157,816,780.00 | 157,816,800.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 18,350,860.00 | 18,350,800.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 14,680,580.00 | 14,680,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,670,100.00 | 3,670,200.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 36,701,420.00 | 36,701,500.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 271,224,960.00 | 175,724,073.27 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 162,224,960.00 | 116,012,080.69 |
| 210302 | Түлш, халаалт | 67,000,000.00 | 37,390,994.12 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 42,000,000.00 | 22,320,998.46 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 128,224,800.00 | 129,136,551.81 |
| 210401 | Бичиг хэрэг | 56,500,000.00 | 71,853,328.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 28,724,800.00 | 28,724,800.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 30,000,000.00 | 13,939,273.81 |
| 210404 | Ном, хэвлэл | 3,300,000.00 | 3,300,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 700,000.00 | 650,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 9,000,000.00 | 10,669,150.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 15,000,000.00 | 15,000,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 15,000,000.00 | 15,000,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 95,732,000.00 | 85,211,125.00 |
| 210602 | Тавилга | 11,732,000.00 | 1,211,300.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 6,000,000.00 | 6,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 78,000,000.00 | 77,999,825.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,542,570.00 | 1,541,613.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,542,570.00 | 1,541,613.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 88,428,000.00 | 81,752,730.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 73,880,000.00 | 67,980,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 750,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 4,000,000.00 | 4,000,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 450,000.00 | 424,730.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 250,000.00 | 250,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 8,000,000.00 | 8,000,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210807 | Газрын төлбөр | 1,098,000.00 | 1,098,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 8,270,000.00 | 13,500,750.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,070,000.00 | 9,940,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,200,000.00 | 3,560,750.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 54,360,550.00 | 54,344,403.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 54,360,550.00 | 54,344,403.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 11,653,320.00 | 11,653,300.00 |
| 213206 | Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт | 400,000.00 | 384,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 31,807,230.00 | 29,807,200.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 10,500,000.00 | 12,499,903.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 2,694,081,110.00 | 2,699,081,400.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 2,694,081,110.00 | 2,699,081,400.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 2,694,081,110.00 | 2,699,081,400.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **327,491,952.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **325,367,052.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 295,950,052.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 178,602,049.00 |
| 210104 | Урамшуулал | 110,880,000.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 67,722,049.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 22,178,042.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 22,178,042.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 39,019,781.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 9,207,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 365,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 22,020,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 7,427,781.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 900,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 900,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 12,511,240.00 |
| 210604 | Урсгал засвар | 12,511,240.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 174,240.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 174,240.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 42,564,700.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 42,564,700.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 29,417,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 29,417,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 29,417,000.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **2,124,900.00** |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 2,124,900.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 2,124,900.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 347,963,460.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 347,963,460.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 330,221,460.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 17,742,000.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баян-Өндөр сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор В.Жавзмаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Баян-Өндөр сумын ЗДТГ нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 03/88 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баян-Өндөр сумын ЗДТГ нь Монгол Улсын хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх болон сумын Засаг дарга, ИТХ-ын бодлого, шийдвэрийг боловсруулах, хэрэгжүүлэхэд чиглэгдсэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгэм төрийн захиргааны байгууллагын стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах, хөтөлбөр төсөл боловсруулах, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх, үнэлгээ өгөх, холбогдох арга хэмжээг зохицуулах үйл ажиллагааг явуулдаг.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллагад дотоод хяналт, аудит хариуцсан ажилтан ажилладаггүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баян-Өндөр сумын ЗДТГ 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 2,699,081.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 40,486.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 28,340.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баян-Өндөр сумын ЗДТГ 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,737,604.1 мянган төгрөгөөр буюу 22.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлттэй гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | | |
| Авлага | 4,500.0 | 38,164.2 | 33,664.2 |
| Бараа материал | 96,671.6 | 117,924.6 | 21,253.0 |
| Үндсэн хөрөнгө | 7,801,805.6 | 9,484,492.5 | 1,682,686.9 |
| **Нийт хөрөнгө** | **7,902,977.2** | **9,640,581.3** | **1,737,604.1** |
| Өр төлбөр | 4,500.0 | 38,164.2 | 33,664.2 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 7,898,477.2 | 9,602,417.1 | 1,703,939.9 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **7,902,977.2** | **9,640,581.3** | **1,737,604.1** |

Авлагын данс 38,164.2 мянган төгрөг болж 33,664.2 мянган төгрөгөөр өссөн нь тус байгууллагад бүртгэлтэй ёс заншлын өргөөний хөв цөөрмийн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл дутуу хийгдэж, орон нутгийн төсөвт төвлөрүүлснээс шалтгаалсан байна.

Бараа материалын данс 117,924.6 мянган төгрөг болж 21,253.0 мянган төгрөгөөр өссөн нь оны эцэст ариутгалын бодис худалдан авснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 9,484,492.5 мянган төгрөг болж 1,682,686.9 мянган төгрөгөөр өссөн нь улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийсэн барилга байгууламж, их засварыг хүлээн авч бүртгэснээс шалтгаалжээ.

Өр төлбөрийн данс 38,164.2 мянган төгрөг болж 33,664.2 мянган төгрөгөөр өссөн нь тус байгууллагад бүртгэлтэй ёс заншлын өргөөний хөв цөөрмийн хөрөнгө оруулалтын ажил гүйцэтгэл дутуу хийгдэж, гүйцэтгэгч байгууллагад санхүүжилтийг бүрэн олгоогүйгээс шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 9,602,417.1 мянган төгрөг болж 1,703,939.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Баян-Өндөр сумын ЗДТГ-ын санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт орлого өмнөх оноос 327,750.9 мянган төгрөгөөр буюу 5.3 хувиар буурч, нийт зардал өмнөх оноос 363,156.9 мянган төгрөгөөр буюу 11.1 хувиар өссөн байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Баян-Өндөр сумын ЗДТГ нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,919,096.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 2,919,096.3 сая төгрөгөөр тооцож, төлөвлөн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Тус байгууллагаас хүргүүлсэн төсвийн төслийг 400,014.9 мянган төгрөгөөр бууруулан 2,519,081.4 мянган төгрөгөөр баталсан байна. Тайлант онд төсвийг 1 удаа тодотгол хийж 180,000.0 мянган төгрөгөөр өсгөж, 2,699,081.4 мянган төгрөгөөр баталжээ. Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, урсгал зардал болон бусад зардлыг нэмэгдүүлж тодотгол хийсэн байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлагын арга хэмжээг хэрэгжүүлэхээр 2,699,081.1 мянган төгрөгийн санхүүжилтийг орон нутгийн төсвөөс авч, урсгал үйл ажиллагаанд 2,602,776.3 мянган төгрөгийг зарцуулж, 96,304.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,602,776.3 мянган төгрөг буюу 96.4 хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг 253.7 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 95,500.9 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 6,675.2 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Орхон аймгийн төсвөөс аймгийн Засаг даргын захирамж болон төсөвт баталсан зарим арга хэмжээний санхүүжилт болох 261,225.0 мянган төгрөгийн санхүүжилтийг нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авсан байна.

Үүнээс 218,614.2 мянган төгрөгийг зарцуулж, 42,610.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудитын хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Баян-Өндөр сумын ЗДТГ нь 2021 онд нийт 3,505,622.8 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 2 мэдээллийг мэдээлэх хугацаа болоогүй, 12 мэдээллийг хугацаа хоцроож, 1 мэдээллийг огт мэдээлээгүй, өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 1,168.3 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 2,680.8 мянган төгрөгийн 1 зөвлөмжийн хэрэгжилтийг 100 хувьтай хангуулсан байна.

Хүснэгт . Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тоо | дүн | тоо | дүн | тоо | дүн | хувь |
| Акт | | | | | | | |
| Албан шаардлага | 1 | 1,168.3 | 1 | 1,168.3 | | | |
| Зөвлөмж | 1 | 2,680.8 | 1 | 2,680.8 | | | |
| Нийт дүн | 2 | 3,849.1 | 2 | 3,849.1 | | | |

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Баян-Өндөр сумын ЗДТГ-т ажилладаггүй, аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэст хамаарах эрх зүйн хөтчийн цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулж олгож байна. Мөн багуудын байр ашиглалтад орж буйтай холбоотойгоор тогтмол зардал нэмэгдэх, байрны ашиглалт хамгаалалт зэрэг нь дараагийн аудитаар анхаарал татахаар асуудал болж байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 397,022.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 130,091.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 502.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 254,708.7 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, хариуцлага тооцуулах 1 албан шаардлага, 11,721.1 мянган төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

### 4.1 Залруулсан алдаа

2022 оны 01 дүгээр сарын 25-нд ирүүлсэн санхүүгийн тайлангийн орлого үр дүнгийн, мөнгөн гүйлгээний болон өмчийн өөрчлөлтийн тайлангийн өмнөх оны гүйцэтгэлийг тайлагнаагүйг залруулсан болно.

Мөн тайлант онд худалдан авсан тоног төхөөрөмжийг мөнгөн гүйлгээний тайланд техник хэрэгсэл, тавилга авах зардалд тайлагнасныг хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардалд залруулж тайлагнасан.

### 4.2 Төлбөрийн акт

Тайлант оны жилийн эцсийн тооллогоор үндсэн хөрөнгө дутаасан байх тул төлбөрийн акт тогтоов.

### 4.3 Албан шаардлага

Засгийн газрын 43 дугаар тогтоолын дагуу төсөвт 10-аас доошгүй хувийн хэмнэлт үүсгэхээр тооцож зарцуулах байсан хэдий ч хэмнэлт үүсгээгүй, хөдөлмөр хамгааллын хувцас худалдан авсан болон багуудын албан хаагчдын цагийн бүртгэл хангалтгүй, бүртгүүлээгүй байтал ажлын цагийг нэгтгэн бодож, цалин олгосоор ирсэн зэрэг зөрчилд 2 албан шаардлага хүргүүлэв.

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. ***Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал***

*1.1. <u>Илрүүлэлт:</u>*

Оны эцсийн халаалтын зардал 3,237.3 мянган төгрөг давхар шилжсэнийг зардлаар тайлагнаж, авлагаар бүртгээгүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т “санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах”; 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, тасалбар болголт, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*1.2. <u>Өгсөн зөвлөмж:</u>*

Өр төлбөрийг тооцооны үлдэгдлийн баталгаагаар баталгаажуулан, 2022 оны эхний хагас жилийн тайланд залруулах.

***2. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал***

*2.1. <u>Илрүүлэлт:</u>*

Тайлант онд худалдан авсан зуух, хард диск, сургалтын самбар, шат зэрэг үндсэн хөрөнгөд бүртгэх бараа материалыг зарцуулснаар тайлагнасан, жилийн эцсийн тооллогын нэгдсэн дүнг гаргахдаа үндсэн хөрөнгө гэж тайлагнасан бөгөөд бараа материалын дүнг тайлагнаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т “санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах”; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”; 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж заасантай нийцэхгүй, ангилал, үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*2.2. <u>Өгсөн зөвлөмж:</u>*

Бараа материалын дэлгэрэнгүй бүртгэлийг нягталж, хөрөнгийн шинж чанартай бараа материалыг 2022 оны эхний хагас жилийн тайланд залруулж, тайлагнах.

Бараа материал, үндсэн хөрөнгийн тооллогыг хийхдээ балансын данс, зүйл бүрээр тулган баталгаажуулж, тооцоо бодож, үнэн зөв тайлагнах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Баян-Өндөр сумын ЗДТГ | 9 | 397,022.8 | 2 | 130,091,0 | 1 | 502.0 | 3 | 254,708.7 | 3 | 11,721.1 |